



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/021/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: Saranchimegtst@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.1 Төлбөрийн акт	8
5.2 Албан шаардлага	8
5.3 Зөвлөмж	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БНСБС	Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.21 № 01/233
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ГОМБОДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсөвт байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 4 орон нутгийн тусгай сан, 1 төрийн сангийн нэгж нийт 15 тайлан нэгтгэгдсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь зөвхөн гүйцэтгэл үр, дүнгээр санхүүжих 7 байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд тайлагнаж нэгтгэлд оруулсан байна.

Тайлант онд сумын сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчлэн засварлаж, орчин үеийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхдүүдийн сурах орчныг сайжруулсан байна. Эрүүл мэндийн төвийг шинэчлэн засварлаж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулсан байна. Сумын соёл, спортын арга хэмжээг зохион байгуулж, иргэдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

412505379

Төв аймгийн Жаргалант сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,449,083.5 мянган төгрөгөөр баталснаас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 02 тоот тогтоолоор 306,634.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,755,717.6 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1,974,803.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 219,086.1 мянган төгрөгөөр буюу 12,5 %-аар давуулан биелүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг дарга болон Сумын засаг дарга нарын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ нь 2024 онд нийт 11 зорилт, 156 хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ дэвшүүлэн ажилласнаас 84 зорилтын хэрэгжилт үр дүнтэй, 21 зорилт тодорхой үр дүнд хүрсэн, 12 зорилт эрчимжүүлэх шаардлагатай, 39 зорилт хэрэгжээгүй бөгөөд гэрээний хэрэгжилт 83,9 % хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,296,972.8	1,680,563.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	634,127.2	1,114,996.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	425,707.4	318,414.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	237,138.2	247,152.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,509,223.3	5,618,918.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,509,223.3	5,618,918.3
39200	Биет хөрөнгө		3,315,708.0	5,129,133.9
39300	Биет бус хөрөнгө	13	193,515.3	489,784.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,806,196.2	7,299,481.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		11,473.8	19,979.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	11,473.8	19,979.4
41300	Өглөг	17а, 17б	11,473.8	19,979.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,794,722.3	7,279,502.0
51	Засгийн газрын хувь оролцоо		4,794,722.3	7,279,502.0
51100	Засгийн газрын оруулсан капитал		471,343.6	471,343.6
51200	Хуримтлагдсан үр дүн		3,612,065.9	6,096,845.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		711,312.9	711,312.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИ		4,806,196.2	7,299,481.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		5,746,909.40	5,299,580.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,219,317.30	1,934,558.00
110	Орлогын албан татвар		959,814.30	1,463,587.10
1100	Хувь хүний орлогын албан татвар		988,814.30	1,463,587.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан с		-29,000.00	0
113	Хөрөнгийн албан татвар		94,258.10	107,591.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		165,244.80	363,379.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,700,629.20	1,892,153.00
120	Нийтлэг татварын бус орлого		1,700,629.20	1,892,153.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,826,962.90	1,472,869.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,252,684.60	2,729,671.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,547,485.30	2,483,441.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,872,149.90	2,455,714.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		545,890.10	795,829.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шим		69,873.90	99,511.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		64,892.50	785,014.90
2104	Хангамж, бараа материалын зардал		41,869.10	51,953.60
2105	Норматив зардал		177,512.20	259,953.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,339.90	31,389.80
2107	Томилолт, зочны зардал		2,944.00	7,759.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тө		8,269.50	25,160.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		959,558.70	399,140.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,675,335.30	27,727.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		705,199.30	246,230.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,494,224.80	2,569,909.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		804.2	85,129.40
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)		1,493,420.60	2,484,779.70

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		4,663,278.40	3,862,880.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,219,317.30	1,934,558.00
110	Орлогын албан татвар		959,814.30	1,463,587.10
1100	Хувь хүний орлогын албан татвар		988,814.30	1,463,587.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан		-29,000.00	0
113	Хөрөнгийн албан татвар		94,258.10	107,591.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		165,244.80	363,379.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		32,639.60	22,687.10
1181	Газрын төлбөр		106,178.60	314,013.10
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		26,426.70	26,679.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		616,998.20	455,453.00
120	Нийтлэг татварын бус орлого		616,998.20	455,453.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,826,962.90	1,472,869.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,192,592.80	2,129,722.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,192,592.80	2,129,722.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,517,257.50	2,101,482.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		544,274.40	796,231.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ши		69,330.40	100,689.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		69,273.30	784,766.90
2104	Хангамж, бараа материалын зардал		42,781.10	50,639.90
2105	Норматив зардал		198,531.30	268,185.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,297.40	33,605.80
2107	Томилот, зочны зардал		2,944.00	7,759.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний т		8,285.10	24,884.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		579,540.50	34,719.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,675,335.30	28,240.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		1,470,685.60	1,733,158.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН		934,753.90	1,251,830.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		934,753.90	1,251,830.00
2200	Дотоод эх үүсвэрээр		934,753.90	1,251,830.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-934,753.90	-1,251,830.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-115,804.20	-459.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР		115,804.20	459.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)		420,127.40	480,868.90
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгд		213,999.70	634,127.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэг	За, 3б	634,127.20	1,114,996.10

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	ЗГ-ын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,299,391.9	0	3,299,391.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлө	2,002.9	0	2,002.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,301,394.8	0	3,301,394.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бу	-93,0	0	-93,0
9	Тайлант үеийн үр дүн	1,493,420.6	0	1,493,420.6
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,794,722.3	0	4,794,722.3
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,794,722.3	0	4,794,722.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,794,722.3	0	4,794,722.3
19	Тайлант үеийн үр дүн	2,484,779.7	0	2,484,779.7

20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,279,502.0	0	7,279,502.0
----	---------------------------------------	-------------	---	-------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,432,307.4	2,733,750.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,098,493.6	1,780,190.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,086,185.6	1,769,490.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	878,774.5	709,251.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,847.2	88,749.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	856,879.7	784,766.9
2104	Хангамж, бараа материалын зардал	70,843.2	44,158.2
2105	Норматив зардал	1,992.3	1,992.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,100.0	64,839.9
2107	Томилот, зочны зардал	7,599.0	6,869.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хура	31,252.0	24,063.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,897.7	44,800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,308.0	10,700.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,308.0	10,700.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,232,313.8	953,100.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	101,500.0	459.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,432,307.4	3,268,769.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	723,103.8	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,139,993.6	3,143,630.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	549,210.0	125,138.4
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	20,000.0	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	84	84
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	41	41
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41	41

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,662.0	374,211.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,662.0	129,223.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,328.7	108,495.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,706.3	83,694.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,963.3	10,415.4
2104	Хангамж, бараа материалын зардал	820.0	5,141.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	1,200.0
2107	Томилот, зочны зардал	0	850.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,494.0	1,956.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,345.1	5,236.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,333.3	20,728.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	17,510.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,333.3	3,218.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	244,988.2
2200	Дотоод эх үүсвэрээр	0	244,988.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,662.0	374,211.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,662.0	374,211.3
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 839,521.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 839,521.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

1. Орлогын гүйцэтгэл тодруулга тайланд ХХС-ийн эргэн төлөлтийн орлого 125,138.4 мянган төгрөг, ОНХС-ийн 714,382.6 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг тайлагнаагүй нэгтгэсэн байна.
2. Авлагын тодруулга тайланд тооцоо нийлсэн актгүй 63.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гэх боловч аль байгууллагаас байгаа нь тодорхойгүй нэгтгэгдсэн байна.
3. Өглөгийн тодруулга тайланд тооцоо нийлсэн актгүй 11,019.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй задаргаагаар БНСБС-ийн 7,020.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэсэн байна.
4. Үр дүнгийн тайланд хоорондын тооцоо үүсгэсэн сургууль, Баянбулаг цэцэрлэгтэй үүсгэсэн хөрөнгийн зардал, мөнгөн гүйлгээний тайланд аймгийн ЗДТГ, Статистикийн хэлтэс хооронд үүсгэсэн хоорондын тооцоо 249,684.5 мянган төгрөгийг хаагаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 117,004.8 мянган төгрөгийн зөрчлөөс 20,108.6 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 34,170.0 мянган төгрөгөөр бага тул "**Зөрчилгүй**" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 117,004.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 96,896.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчлийн давтан гаргахгүй байх 20,108.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй болно.

5.2 Албан шаардлага

Тасарсан орлогыг нэр төрлөөр нь ангилбал малын тоо толгойн албан татвар 40,495.3 мянган төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 13,895.0 мянган төгрөг, галт зэвсгийн албан татвар 30.0 мянган төгрөг, ойн төлбөр 6,280.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогын албан татвар 36,195.2 мянган төгрөгөөр нийт 5 төрлийн орлого 96,896.2 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.5-д “хариуцлагатай байх”, 23 дугаар зүйлийн 23.1-д “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”, 23.8-д “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Татварын орлогын мэдээнээс харахад 6 нэр төрлийн орлого 235,843.0 мянган төгрөгөөр дутуу, 5 нэр төрлийн орлого 224,694.5 мянган төгрөгөөр илүү нийт дүнгээр 11,148.6 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, 24.3-д “Татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогын мэдээг үнэн зөв мэдээлж буй эсэхэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах

2.Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд Өгөөмөр 2-р багт байрлах хогийн цэгийг нүх ухаж, хашаажуулах, тохижуулах ажил хийхээр Чамин хаус ХХК-тай 44,800.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан, 2021 оны 10 дугаар сарын 04-нд урьдчилгаа 50,0 хувь болох 22,400.0 мянган төгрөг, 2021 оны 11 дүгээр сарын 03-нд явцын санхүүжилт болох 13,440.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд нийт гэрээний үнийн дүнгийн 80,0 хувийг тухайн аж ахуйн нэгжид шилжүүлсэн байна. Гэвч тайлант онд үлдсэн 20,0 хувийн ажил болох агуулахын барилгын цонх, хаалгыг хийж гүйцэтгэж дуусгалгүй өнөөдрийг хүрсэн зөрчилтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Чамин Хаус ХХК-иар дутуу ажлыг хийж гүйцэтгүүлэн ажлыг хүлээн авч данс бүртгэлд тусгах

3. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан заавар журамтай холбогдуулан шинэчлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, батлуулах, мөн хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулж, санхүүгийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажил зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Засаг дарга	4	1,093,268.3	1	839,521.0	3	253,747.3	4	1,093,268.3				
Дүн	4	1,093,268.3	1	839,521.0	3	253,747.3	4	1,093,268.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	4	117,004.8			1	96,896.2	3	20,108.6
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	875.5	1	875.5				
Засаг даргын тамгын газар	2	17,375.5	1	875.5	1	16,500.0		
Хоршоо хөгжүүлэх сан	1	64,398.7					1	64,398.7
Эмийн эргэлтийн сан	2	5,619.2			2	5,619.2		
Дүн	10	205,273.7	2	1,751.0	4	119,015.4	4	84,507.3

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Өөрчлөлттэй		
санал дүгнэлт гаргах		Түүвэрт хамрагдах	Аудит хийгээгүй	Хязгаарлалттай		Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	2	3	4	5	6	7	8	9
Төсвийн шууд захирагч	2	1	1		1			
Орон нутгийн тусгай сан	4		4					
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1			1			
Орон нутгийн өмчит газар	1			1				
Дүн	8	2	5	1	2		-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn